



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 204 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 70532849, Факс: (976) 70532111
Цахим шуудан: info@omnogovi.gov.mn
Цахим хуудас: www.omnogovi.gov.mn

2024.03.14 № 02/559

танай _____ -ны № _____ -т

Тодруулга оруулах тухай

“Нэйшн арена цогцолборын зураг төсөл боловсруулах” ӨМАХААГ/20240101643 дугаартай ажилд тодруулгын хариу хүргүүлэх тухай.

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1-д заасны дагуу Ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн гурав хүртэлх жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн нотлох баримт ирүүлж болно.

2. Дээрх инженер, техникийн ажилтнуудын 50 хувиас доошгүй хувь нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх шаардлагатай бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийг 12 сар буюу 2023 оны 01, 02, 03, 04, 05, 06, 07, 08, 09, 10, 11, 12 дүгээр саруудад тендерт оролцогч тасралтгүй төлсөн болохыг шаардана.

3. Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 40 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх бөгөөд олон нийтийн барилга байгууламжийн зураг, төслийн ажил гүйцэтгэсэн гэрээ, магадлалын дүгнэлт, акт, тухайн ажлыг цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэсэн тухай захиалагч байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.

ДАРГА



Ц.АМАРТӨГС